



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар A/73

Жаргалтхаан

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын А/58 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Гичгэнэ багийн нутаг дэвсгэрт малын гоц халдварт хонины цэцэг өвчин гарч, хорио цээрийн дэглэм тогтоож, сүүлийн сэжигтэй малыг устгаснаас хойш 21 хоногт өвчний шинж тэмдэг дахин илрээгүй тул хорио цээрийн дэглэмийг цуцалж, хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Голомтын бүсээс мал, мах бэлтгэх, тээвэрлэх, малын шилжилт хөдөлгөөн хийхийг 14 хоногийн хугацаанд түр хориглосугай.

3. Голомтын бүс нутагт хөдөлгөөнт эргүүл томилж, хүн малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт, тухайн бүс нутагт нутаглаж буй малчдын суурьт үзлэг тандалт хийж, мал эмнэлгийн нэгжүүдэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга С.Жавзандуламд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232431169